



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 512

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.4, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Чех Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 109,872.40 (нэг зуун есөн мянга найман зуун далан хоёр ам.доллар дөчин цент) ам.долларын балансын үнэ, 51,884.19 (тавин нэгэн мянга найман зуун наян дөрвөн ам.доллар арван есөн цент) ам.долларын хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Бүгд Найрамдах Чех Улс дахь Монгол Улсын Элчин сайд Н.Наранбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30 -ны өдрийн
518 дугаар тогтоолын хавсралт



**Бүгд Найрамдах Чех Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, сэлбэгээр худалдах хөрөнгийн жагсаалт**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (ам.доллар)	Хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Үлдэх өртөг (ам.доллар)	Сэлбэгээр худалдах доод үнэ (ам.доллар)
1	"Benz S350", 032CD40, суудлын, арлын дугаар - WDD2211821A484002	2011/2012	120000	109,872.40	51,884.19	57,988.21	1,000.00
	НИЙТ ДҮН			109,872.40 (нэг зуун есөн мянга найман зуун далан хоёр доллар дөчин цент)	51,884.19 (тавин нэгэн мянга найман зуун наян дөрвөн доллар арван есөн цент)	57,988.21 (тавин долоон мянга есөн зуун наян найман доллар хорин нэгэн цент)	1,000.00 (нэг мянган доллар)